



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/035/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас:51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Аудитор: Г.Тэлмүүн Утас: 51-261740 Цахим хаяг: telmuung@audit.gov.mn Азуре хүлүг аудит ХХК-ийн захирал: Г.Мөнхбаяр Утас:70110090 Цахим хаяг: audit@azure.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.13 № 07/9248
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг, бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант хугацаанд улсын төсвийн 1,092.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн их засварын зардлыг капиталжуулж ТӨБЗГ-ийн 2024 оны 676 дугаар тогтоолоор эздийн өмчийн бусад хэсгийг нэмэгдүүлсэн байна.

Үйлдвэрийн газар нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг бүртгэхдээ НББОУС-20 "Засгийн газрын буцалтгүй тусламжийн тайлагнал ба Засгийн газрын туслалцааны тодруулга"-д заасан капиталын хандлагыг хэрэглэж ашиг, алдагдлаас гадуур байдлаар хүлээн зөвшөөрсөн байна. Уг стандартын 17 дахь хэсэгт "...элэгдүүлэх хөрөнгөтэй холбоотой буцалтгүй тусламжийг ихэвчлэн тэдгээр хөрөнгийн элэгдлийн зардлыг хүлээн зөвшөөрсөн тайлант үеүдийн туршид, элэгдлийн зардалтай хувь тэнцүүлэн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө" гэж заасан бөгөөд энэ нь үйлдвэрийн газрын дараагийн санхүүгийн тайлангийн жилүүдэд зохистой байж болно.

Тус үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд нөлөөлөх Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль 2024 оны 06 сарын 05-ны өдөр батлагдсан. Уг хуулийн 9 дүгээр зүйлд нийцүүлэн Мэдээлэл технологийн үндэсний паркийн дүрмийг шинэчлэх шаардлага үүссэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

ТӨБЗГ-ын 2024 оны 453 дугаар тогтоолоор эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үйлдвэрийн газрын тайлант хугацааны орлого үйл ажиллагаанд хамааралгүй И-монгол академиас хүлээн авах барилгын их засвар, лифт болон бусад хөрөнгөтэй холбоотой 1,040.0 сая төгрөгийн орлого, 377.9 сая төгрөгийн зардлаар тус тус нэмж тодотгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгасан асуудал нь хамрахгүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хөрөглөгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3,383,133.82	1,309,422.80
1.1.2	Дансны авлага	224,758,843.59	268,840,774.82
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	30,878,159.91	20,066,943.53
1.1.4	Бусад авлага	88,244,311.00	74,904,485.00
1.1.6	Бараа материал	120,989,265.12	121,302,505.61
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	500,028.02	149,229.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	468,753,741.46	486,573,360.76
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,766,260,887.40	4,519,305,579.14
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,766,260,887.40	4,519,305,579.14
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,235,014,628.86	5,005,878,939.90
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	76,679,479.73	37,170,810.00
2.1.1.2	Цалингийн өглөг	111,331.00	694,510.00
2.1.1.3	Татварын өр	3,581,903.36	32,599,164.51
2.1.1.4	НДШ - ийн өглөг	-	13,473,152.51
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	736,658,876.11	340,426,067.51
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	13,001,327.51	16,089,832.33
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	830,032,917.70	440,453,536.86
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	2,828,390.70	2,330,388.15
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,828,390.70	2,330,388.15
2.2	Өр төлбөрийн нийт дүн	832,861,308.40	442,783,925.01
2.3	Эзэмшигчдийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	1,021,630,200.00	1,021,630,200.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,042,193,559.47	3,042,193,559.47
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	789,494,381.42	1,881,956,742.72
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,451,164,820.43)	(1,382,685,487.29)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	3,402,153,320.46	4,563,095,014.89
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	4,235,014,628.86	5,005,878,939.90

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	908,941,302.88	1,339,424,984.61
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	21,547,844.10	27,855,380.43
3	Нийт ашиг (алдагдал)	887,393,458.78	1,311,569,604.18
4	Түрээсийн орлого	414,968,508.81	-
5	Хүүгийн орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	664,169,287.07	1,172,919,107.22
9	Борлуулалт, маркетингийн зардал	146,244,981.52	146,498,496.89
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,019,765,734.34	2,245,590,362.28
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(1,695,034.34)	(926,344.40)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(8,140.95)	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(201,182,636.49)	91,473,507.83
19	Орлогын татварын зардал	-	9,147,350.78
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(201,182,636.49)	82,326,157.05
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(201,182,636.49)	82,326,157.05
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
25	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
26	Бусад олз (гарз)	-	-
27	Орлогын нийт дүн	(201,182,636.49)	82,326,157.05

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээ	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2022 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	1,021,630,200.00	3,207,725,219.64	789,494,381.42	(1,387,419,732.49)	3,631,430,068.57
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	137,437,548.56	137,437,548.56
Залруулсан үлдэгдэл	1,021,630,200.00	3,207,725,219.64	789,494,381.42	(1,249,982,183.94)	3,768,867,617.13
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(201,182,636.49)	(201,182,636.49)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	(165,531,660.18)	-	-	(165,531,660.18)
2023 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	1,021,630,200.00	3,042,193,559.47	789,494,381.42	(1,451,164,820.43)	3,402,153,320.46
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	(13,846,823.91)	(13,846,823.91)
Залруулсан үлдэгдэл	1,021,630,200.00	3,042,193,559.47	789,494,381.42	(1,465,011,644.34)	3,388,306,496.55
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	82,326,157.05	82,326,157.05
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	1,092,462,361.30	-	1,092,462,361.30
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-	-
2024 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	1,021,630,200.00	3,042,193,559.47	1,881,956,742.72	(1,382,685,487.29)	4,563,095,014.89

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,886,188,471.18	2,120,501,327.19
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,066,840,898.22	1,218,961,655.97
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	848,217.00	1,182,079.00
	Бусад мөнгөн орлого	818,499,355.96	900,357,592.22
1.2	Мөнгөн зарлага (-)	1,865,466,787.88	2,108,364,462.16
	Ажиллагчдад төлсөн	587,528,697.00	730,240,484.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	178,983,321.58	212,131,159.75
	Бараа материал худалдан авахад төлсөн	67,675,564.00	81,807,614.00
	Ашиглалтын зардалд төлсөн	154,122,381.37	159,050,742.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	9,887,000.00	8,234,000.00
	Татварын байгууллагад төлсөн	197,842,899.76	255,164,374.96
	Даатгалын төлбөрт төлсөн	956,767.00	1,721,179.00
	Бусад мөнгөн зарлага	668,470,157.17	660,014,908.45
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	20,721,683.30	12,136,865.03
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	35,784,231.60	26,856,549.57
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	35,784,231.60	26,856,549.57
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	50,871,882.60	48,789,882.07
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	29,574,450.00	18,901,342.00
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	21,297,432.60	29,888,540.07
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(15,087,651.00)	(21,933,332.50)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	113,841,000.00	16,267,800.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	113,341,000.00	16,267,800.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	500,000.00	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	126,108,122.00	8,545,043.55
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	124,626,572.00	8,545,043.55
	Төлсөн ногдол ашиг	1,481,550.00	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(12,267,122.00)	7,722,756.45
3.4	Валютын ханшийн зөрүү	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(6,633,089.70)	(2,073,711.02)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,016,223.52	3,383,133.82
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,383,133.82	1,309,422.80

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2023 оны Гүйцэтгэл	2024 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	2	3	4	5	6	7	8
	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт						
	Түрээсийн орлого	мян.төг	837,119.4	1,208,137.7	1,258,090.8	49,953.1	104.1
	Бусад орлого	мян.төг	45,340.7	-	-	-	-
	Бусад орлого/Экспо,И-Монгол академис	мян.төг	414,968.5	1,040,022.6	237,653.3	(802,369.3)	22.9
	АСПА 2024 зохион байгуулах орлого	мян.төг	-	65,101.2	65,101.2	-	100.0
	Сургалт, шалгалт, төсөл хөтөлбөрийн орлого	мян.төг	214,103.0	518,643.3	358,673.8	(159,969.6)	69.2
	Инкубаторын үйл ажиллагааны орлого	мян.төг	219,541.6	181,220.4	191,271.9	10,051.5	105.5
	"Эко систем" хөтөлбөрийн орлого	мян.төг	223,426.0	237,313.9	228,924.8	(8,389.2)	96.5
	Технологи дамжуулах төвийн орлого	мян.төг	26,481.2	45,000.0	60,165.8	15,165.8	133.7
	Хандив тусламжийн орлого	мян.төг	219,140.3	297,950.2	298,535.1	584.9	100.2
2	Нийт орлого	мян.төг	2,200,120.7	3,593,389.4	2,698,416.6	(894,972.8)	75.1
3	Нийт зардал	мян.төг	2,401,303.3	3,580,238.2	2,606,942.5	(973,295.7)	72.8
3.1	Үүнээс: Удирдлагын зардалд	мян.төг	158,832.6	225,261.8	242,332.7	17,070.9	107.6
4	Татварын өмнөх ашиг /алдагдал	мян.төг	(201,182.6)	13,151.2	91,474.1	78,322.9	695.6
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	(201,182.6)	11,836.1	82,326.7	70,490.6	695.6
6	Төсвийн төлбөр	мян.төг	396,356.4	382,170.7	512,084.5	129,913.8	134.0
7	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	1,481.6	-	-	-	-
8	Ажиллагсдын тоо	хүн	37	43	38	(5)	88.4
9	Нийт цалингийн сан	мян.төг	644,330.0	977,912.4	800,395.9	(177,516.5)	81.8
10	Нэг ажилтны сарын дундаж цалин	мян.төг	1,451.2	1,895.2	1,755.3	(139.9)	92.6
11	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	0.9	1.0	0.9	(0.1)	97.0
12	Хөрөнгө оруулалт	мян.төг	37,768.9	84,645.0	59,351.5	(25,293.4)	70.1
13	Нийт авлага	мян.төг	343,881.3	256,251.8	363,812.2	107,560.4	142.0
14	Нийт өглөг	мян.төг	832,861.3	381,690.7	442,783.9	61,093.2	116.0
14.1	Үүнээс: богино хугацаат өр төлбөрт	мян.төг	93,374.0	38,085.0	100,027.5	61,942.4	262.6
14.2	УОО/хандив/	мян.төг	736,658.9	341,825.9	340,426.1	(1,399.9)	99.6
14.3	Урт хугацаат өр төлбөрт	мян.төг	2,828.4	1,779.7	2,330.4	550.6	130.9

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 4.3 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 2.9 сая төгрөгийн алдааг залруулж, 1.4 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Тайлант хугацааны эцсээр 2.8 сая төгрөгийн үйл ажиллагааны орлогыг дутуу тусгасан байна.	1	2,853.0	1	2,853.0	-	-	1	2,853.0	-	-	-	-
2	Бараа материалын үлдэгдлийг тулган шалгахад 0.6 сая төгрөгийн өртөгтэй 1 ширхэг үндсэн хөрөнгийг дансны ангилал зөрүүтэй бүртгэсэн, ашиглалтын хугацаа дууссан 10 ширхэг эмийг зарлагдаагүй байна.	1	584.9	-	-	1	584.9	-	-	1	584.9	1	584.9
3	Өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн акттай тулгаж шалгахад Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-д төлөх өрийн үлдэгдэл 0.8 сая төгрөгөөр дутуу тайлагнагдсан байна.	1	842.8	-	-	1	842.8	-	-	1	842.8	1	842.8
	Дүн	3	4,280.7	1	2,853.0	2	1,427.7	1	2,853.0	2	1,427.7	2	1,427.7

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

3.2 Аудитаар нийт 2.8 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 0.4 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 2.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Гадаад албан томилолтын зардлыг Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалд зааснаас 0.4 сая төгрөгөөр илүү тооцож олгосон байна.	1	438.9	1	438.9	-	-	-	-	-	-	-	-
2	ТӨБЗГ-аас баталсан албан тушаалын жагсаалт, орон тоонд тусгагдаагүй, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг хариуцсан ажилтны ажлыг шаардлага хангаагүй ажилтанд хавсран гүйцэтгүүлэх тушаал гаргаж үндсэн цалингийн 20 хувьтай тэнцэх хэмжээний нийт 2.4 сая төгрөгийн нэмэгдлийг олгосон байна.	1	2,445.2	-	-	1	2,445.2	-	-	-	-	-	-
	Дүн	2	2,884.1	1	438.9	1	2,445.2	-	-	-	-	-	-

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 зөрчил³ илэрснээс 1 албан зөвлөмж хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/			
			Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Мэдээлэл технологийн үндэсний паркийн хамтын гэрээний нийцлийн асуудлыг шалгахад дараах зөрчил илэрлээ. 1. Хамтын гэрээний 2.3 дахь заалтад ээлжээр ажиллах ажилтны илүү цагийн тооцоолол, ажиллах цагийг хэрхэн бүртгэхийг тодорхой тусгаагүй, 2. Хамтын гэрээний 2.13.1 дэх хэсэгт заасан өндөр насны тэтгэвэрт гарч байгаа ажилтан, албан хаагчид мөнгөн тэтгэмжийн олгох зохицуулалтыг ерөнхий байдлаар тэмдэглэсэн, 2.13.2-т заасан тэтгэмж бодох хугацаа, аргачлал Хөдөлмөрийн тухай хуулийн 82.1-д зааснаас өөр байдлаар тусгасан, 3. Хамтын гэрээний 3.3 дахь заалтаар албан хаагч шинэ байшин, орон сууцанд ороход олгож буй буцалтгүй тусламжийг ямар шалгуураар олгох нь тодорхойгүй байна.	1	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	1	-

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.